ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр Дугаар А/172 Рашаант сум

Шинжилгээнд хамруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дахь хэсэг, 23.5 дахь хэсэг, Хөвсгөл аймгийн засаг даргын А/305 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын бруцеллёз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх азарганаас бусад хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний халдвар илрүүлэх тандалт шинжилгээг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Бруцеллёзийн шинжилгээг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны хооронд үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн нэгжийн малын их эмч (Г. Дарханочир, Ц. Зоригт, Ч. Наранцэцэг) нарт даалгасугай.

3.Бруцеллёз өвчнийг ирүүлэх тандалт судалгааны хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Д. Батхуяг)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б. Идэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.АЛТАНГЭРЭЛ

D:\nasaa bichig hereg\A-Zax.doc

6706011132